

**БАЯНБУЛАГ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН
1-Р УЛИРАЛД ХИЙСЭН АЖЛЫН ТАЙЛАН**

2026 оны 03 дугаар сарын 26

Бүрд

Нэг.Удирдлага зохион байгуулалтын талаар:

УИХ-ын гишүүн Гадаад харилцааны сайд Б.Батцэцэг, Аймгийн Засаг дарга Э.Энхбат, Засаг даргын орлогч Б.Наранбаяр нарын бүрэлдэхүүнтэй ажлын хэсэг тус сумд ажиллаж төрийн албан хаагчид, иргэд хөдөлмөрчдөд төрзасгийн бодлого шийдвэрийн талаар мэдээлэл өгч сум орон нутгийнхаа хөгжил цэцэглэлтийн төлөө залуу нас хүч хөдөлмөрөө зориулан ажилласан ахмад настан болон иргэдэд төрийн дээд шагнал одон медаль, салбарын шагналуудыг гардуулж алдаршууллаа.Сумын Засаг даргын Тамгын газраас "Малчид төлчдийн зөвлөгөөн зохион байгууллаа.Энэ зөвлөгөөнд сумын Засаг дарга Д.Батболд, ИТХ-ын дарга Ч.Эрдэнэбилэг, Засаг даргын Тамгын газрын мал эмнэлэг, хөдөө аж ахуйн тасаг, нийт ажилтнууд оролцож шинээр гарсан хууль тогтоомж аймаг, сум орон нутгаас хийж хэрэгжүүлж байгаа ажлын мэдээлэл танилцуулгыг тус тус хийлээ Малчид төлчдийн дунд волейбол, олс таталты тэмцээн, улсын цолтой бөхийн барилдааныг зохион байгууллаа.

"Цагаан сар" үзэсгэлэн худалдаа"-г зохион байгууллаа.

Засаг даргын Тамгын газар, Эмэгтэйчүүдийн зөвлөл, соёлын төвөөс санаачлан зохион байгуулан явуулсан баг сурталчлах урлагийн наадамд баг байгууллагууд амжилттай оролцож Сангийн далайн 1 дүгээр баг, 2-р байрыг Ар жаргалант 2-р баг, 3-р байрыг Бүрд 4-р баг тус тус эзэлж өргөмжлөл, мөнгөн шагнал гардан авсан.

Баянхонгор аймгийн ГБХЗХГ-ын дарга Н.Мэндбаяр даргатай ажлын хэсэг тус сумд ажиллаж сумын хэмжээнд гэр бүл, хүүхдийн хүчирхийлэлийн эсрэг ажил үйлчилгээ явуулах тандалт судалгаа хийх талаар зөвлөн туслах үйлчилгээг үзүүлж сургалт зохион байгууллаа.

ГБХЗХГ-аас олгосон гэрийг Засаг даргын зөвлөл буюу удирдлагын багийн хурлаар хэлэлцэж 1-8 насны 4 хүүхэдтэй залуу малчин Т.Бумжидын гэр бүлд олгохоор шийдвэрлэж хүлээлгэн өглөө.

2026 оны цэргийн тоо бүртгэлийн ажлыг хуулийн дагуу Засаг даргын захирамжаар томилогдсон ажлын хэсэг явуулж цэргийн штабт мэдээ тайланг хугацаанд нь өглөө.

Монгол Улсын Үндсэн хуулийн өдрөөр 2026 оны 01 дүгээр сарын 01-нээс эхлэн хэрэгжиж буй хууль тогтоомжийн талаар сургалт зохион байгууллаа.

Төрийн албан хаагчдын дунд "Дэвжээ" тэмцээнийг явууллаа.

Суралцагч аймаг-2025 төслийн хүрээнд иргэдийн оролцоог идэвхтэй хангаж орчны бохирдлыг бууруулан аюулгүй амьдрах орчныг бүрдүүлэхэд бодит үр дүн гаргасныг үнэлж Эрүүл аюулгүй орчин бүрдүүлэгч шилдэг сумаар шалгарч өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдлаа.

Тус сумынхаа малчдаас ажил хөдөлмөрөөрөө шалгарсан 1 дүгээр багийн малчин Г.Ганын гэр бүл, 2 дугаар багийн малчин Э.Мөнхбаярын гэр бүл, 3 дугаар багийн малчин Р.Жамбалдоржийн гэр бүлүүдэд аймгийн Санхүү төрийн сангийн хэлтсийн дарга С.Байгалмаагаар ахлуулсан ажлын хэсэгтэй сумын удирдлагууд, ХАА-н мэргэжилтнүүд "Аймгийн аварга малчин"-ны шагналыг хотонд очиж гардуулж алдаршууллаа.

Аймгийн "Удирдах ажилтаны зөвлөгөөн"-д ИТХ-ын дарга, Засаг дарга, төрийн байгууллагуудын дарга, эрхлэгч нарын бүрэлдэхүүнтэй бүрэн оролцлоо. 2025 оны Засаг даргын Тамгын газрын үйл ажиллагаанд хийсэн хяналт шинжилгээ үнэлгээний дүнгээр 3 дугаар байрт шалгарч өргөмжлөл мөнгөн шагналаар шагнагдсан амжилт үзүүлээ.

Хоёр.Эдийн засаг, төсөв санхүүгийн бодлогын хүрээнд

Санхүүгийн алба төсөвт байгууллагуудын батлагдсан төсвийг зүйл заалтын дагуу санхүүжилтийн сарын хуваарийн дагуу гүйлгээг хийж байгууллагуудын цалин бусад гүйлгээг хугацаанд нь хянаж олголоо. Төрийн өмчийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа үйлчилгээ худалдан авах хуулийн дагуу үнэлгээний хороо ЕБС, Цэцэрлэг дээр сонгон шалгаруулах тендерийг зохион байгууллаа. Төсөвт байгууллагуудын 2025 оны санхүүгийн баримтыг аудитаар оруулж шалгуулж зөрчилгүй дүгнэлт авсан

Гурав.Хууль эрх зүйн бодлогын хүрээнд

Засаг даргын Тамгын газраас эрх зүйн сургалт сурталчилгааны төлөвлөгөөний дагуу 2026 оны 1 сарын 1-нээс эхлэн хэрэгжих хуулиудын талаар сургалт зохион байгуулсан.

Иргэний 8 төрлийн бүртгэлийн төрсний бүртгэлд 4, иргэний цахим үнэмлэх олголтын бүртгэлд 10, шилжилт хөдөлгөөн 2, нас барсаны бүртгэл 1, биеийн давхцахгүй өгөгдөл 12, гадаад паспорт олголт болон бүртгэл 14 хийж мэдээллийн санд орууллаа. Нотиаротын үйлчилгээ гэрээ итгэмжлэл 13, бичиг баримтын хуулбарын үнэн зөвийг баталсан 8 хүнд хийж үйлчилсэн.

Билгийн тооллын хаврын тэргүүн сарын баярын өдрүүдэд нийтийн эргүүл ажиллуулах засаг даргын захирамж гарган хуваарийн дагуу эргүүлийн үүрэг 4 цагийн зайтай гүйцэтгүүлж мэргэжлийн удирдлагаар цагдаагийн хэсгээс ханган ажилласан.

2026 оны 03 дугаар сарын 25-ны байдлаар Засаг даргын захирамж 25, Засаг даргын Тамгын газрын даргын тушаал 6, Тамгын газарт дээд байгууллагаас ирсэн бичиг 50, үүнээс хариутай 6 бичгээс одоогийн байдлаар 5 бичгийн хариуг явуулж 1 бичгийн хариу өгөх хугацаа болоогүй, дээд байгууллагад явуулсан бичиг 19 бүртгэгдсэн бичиг хэргийн эргэлтийн мэдээтэй байна.

Иргэдэд төрийн бодлого шийдвэр, цаг үеийн ажлуудыг ЗДТГ-ын цахим сайт болон пэйж группээр мэдээ мэдээллийг түргэн шуурхай хүргэхэд анхаарч иргэдийг тогтмол мэдээллээр ханган ажиллаж байна.

Нийгмийн хамгааллын бодлогын чиглэлээр:

Нийгмийн даатгалын сангаас болон халамжийн сангаас олгох тэтгэвэр тэтгэмжүүдийг цаг хугацаанд нь тавьж олгоод байна.

Тав Хөдөө аж ахуйн бодлогын хүрээнд:

Малчид төлчдийн зөвлөгөөнийг амжилттай зохион байгууллаа. Энэ зөвлөгөөнд аймгийн НҮБ-ын мал эмнэлгийн төслийн зохицуулагч Б.Энхтөр сургалт мэдээллийг явууллаа. Малчдын зөвлөгөөн дээр тэргүүний малчдыг аймгийн тэргүүний ажилтан, Засаг даргын жуух бичгээр шагнаж урамшуулсан. Салбар салбарын төлөөлөл мэдээлэл, танилцуулга, сургалт хийж энэ зөвлөгөөнөөс малчид иргэд сонсож мэдсэн зүйл ихтэй шинээр санаачлах хүсэл тэмүүлэлтэй үр өгөөжтэй зөвлөгөөн болсон нь онцлог байлаа. Хөдөө аж ахуйн тасгаас "Цагаан сар үзэсгэлэн худалдаа" зохион байгуулж амжилттай оролцож тэргүүлсэн малчид, иргэдийг шагнаж урамшуулсан. 2-р сард сумд үйл ажиллагаа явуулж буй 12 хүнсний дэлгүүрт хяналт шалгалт зохион байгуулсан.

Эрхэм хэрэглэгч аяны хүрээнд Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд "Хүүхэд эрхэм хэрэглэгч" сургалт мэдээлэл АХА тэмцээнийг зохион байгуулж явуулсан.

Сумын хэмжээнд мал төллөж эхэлсэн мал төллөлт 30 хувьтай байна.

Байгаль орчин газрын харилцааны чиглэлээр:

Цагаан сараа хоггүй угтах ажлын хүрээнд нийтийн эзэмшлийн гудамж талбайн хогийг ард иргэдийн дэмжлэгтэйгээр цэвэрлэж хог хаягдлын карьерт асгасан.

Засаг даргын Тамгын газрын эрчүүд хамтран эзэнгүй нохой устгах ажлыг явууллаа. Нийт 22 нохой устгаж иргэдэд нохойгоо өглөө 6-23 цаг хооронд уяж хэвшихийг анхааруулж хууль тогтоомжийг танилцуулж ажилласан. Баянбулаг сумын цахим групп болон "Байгаль орчноо хамгаалъя" цахим группүүдэд байгаль орчинтой холбоотой мэдээллийг байршуулж иргэдийг мэдээллээр цаг тухай бүр ханган ажиллаж байна.

Бусад ажлын талаар:

Билгийн тооллын хаврын тэргүүн сарын шинийн нэгний нэгдсэн золголтыг сумын соёлын төвд 2-р сарын 18-нд зохион байгуулсан. Нэгдсэн золголтоор сумын аварга малчин өрхүүдээ тодруулж шагналыг гардуулсан. Нийт 6 малчин өрх 12 хүн сумын аварга малчнаар шалгарсан. Байгууллага бүр 2025 оны аваргуудаа тодруулж шагнал урамшлыг гардуулж өглөө.

2-р сарын 27-нд бөхийн өргөөнд Баянхонгор аймгийн сар шинийн нэгдсэн золголт зохион байгуулагдлаа.

Сумын нэгдсэн золголтыг Улаанбаатар хот дахь Нутгийн зөвлөлийн засаг дарга Ж.Мөнхсайхан Нарун төвд зохион байгуулж нийт 120 гаруй өндөр настан, нутгийн уугуул суугуул иргэд оролцсон өргөн дэлгэр золголт боллоо. Энэ ажиллагаанд сумын ИТХ-ын дарга Ч.Эрдэнэбилэг, Засаг дарга Д.Батболд, ЗДТГ-ын мэргэжилтэн, албан хаагчдын бүрэлдэхүүнтэй оролцсон.

Сумд үйл ажиллагаа явуулж буй төрийн бус байгууллагуудын удирдлагуудыг Засаг дарга хүлээн авч уулзалт зохион байгууллаа. 2026 онд тэдний үйл ажиллагааг дэмжин хамтран ажиллахаа илэрхийлэв.

Эхний 1 дүгээр улирлын байдлаар:

Баяраа багштай Жудо бөхийн дугуйлангийн сурагчдад уралдаан тэмцээнд оролцоход шатахууны дэмжлэг 300,000 төгрөг

Мартын 8-наар эмэгтэйчүүдийн зөвлөлийн үйл ажиллагааг дэмжин 500,000 төгрөг,

Эрчүүдийн холбооны хүсэлтийг дэмжиж 486,000 төгрөг

Боловсролыг дэмжих жилийн хүрээнд Улсын математикийн олимпиадыг угтсан ажлын хүрээнд Математикийн багийн олимпиадыг ивээн тэтгэн оролцсон. Энэ багийн олимпиадад 500,000 төгрөгийг тус тус Засаг даргын нөөцөөс гаргаж шийдвэрлэн ажиллалаа.

ХЯНАСАН:

ЗАСАГ ДАРГА

ТАЙЛАНГ НЭГТГЭСЭН

ТАМГЫН ГАЗРЫН ДАРГА



Д.БАТБОЛД

Д.ЦЭНД-АЮУШ